



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 98

Мандалговь

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит 12 дугаар хуралдаанаар хэлэлцэх
асуудлыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.1 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 12 дугаар хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

- 1.1 Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөрт /2018-2028/ өөрчлөлт оруулах тухай
- 1.2 Аймгийн 2019 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай
- 1.3 Аймгийн 2020 оны төсөв тодотгох тухай
- 1.4 Мал эмнэлгийн ажил үйлчилгээний тариф батлах тухай
- 1.5 Орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авах тухай

Хоёр. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой санал шийдвэрийн төсөл боловсруулан ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож), аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР





**ДУНГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 99

Мандалговь

Г

Г

Түгээмэл тархацтай ашигт малтмалын
хайгуулын тусгай зөвшөөрөл олгох
эсэхэд санал өгөх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.12 дахь заалт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Дундговь аймгийн Гурвансайхан, Сайхан-Овоо сумдын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийх хүсэлт гаргасан хавсралт дахь аж ахуйн нэгжид хайгуулын тусгай зөвшөөрөл олгох саналыг дэмжсүгэй.

Хоёр. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/ даалгасугай.

ДАРГА  С.СҮХБААТАР





ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БОЛОМЖТОЙ ТАЛБАЙ

| Д/д | Өргөдлийн дугаар | Сумын нэр | Аж ахуйн нэгжийн нэр | Талбайн нэр | Уртраг | Өргөрөг | Талбайн хэмжээ га |
|-----|--------------------|--------------|----------------------|-------------|-----------------|----------------|-------------------|
| 1. | XA-48000040-001-NE | Гурвансайхан | "Галзоо хан" ХХК | Чулуут | 106° 38' 41.18" | 45° 16' 8" | 372.43 |
| | | | | | 106° 38' 41.18" | 45° 15' 51.52" | |
| | | | | | 106° 44' 17.1" | 45° 15' 51.52" | |
| | | | | | 106° 44' 17.1" | 45° 16' 8" | |
| 2. | XA-48000143-001-NE | Сайхан-Овоо | "Пүрэвбат хишиг" ХХК | Бадрах овоо | 104° 18' 8.07" | 45° 42' 28.35" | 49.47 |
| | | | | | 104° 18' 8.07" | 45° 42' 42.94" | |
| | | | | | 104° 17' 17.26" | 45° 42' 42.94" | |
| | | | | | 104° 17' 17.26" | 45° 42' 28.35" | |